



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020 Э-сонин

9-Р САР

86-р дугаар






Зах зээлийн тойм


/2020.09.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	21
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	1,838,602,480
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	1,806,220,850
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	0
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	32,381,630
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	14,470,351
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	14,470,029
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	0
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	322
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	5,898


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	194
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	167
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	134

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс: Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.09.30-ны байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	БиДиСек ХК	6,703,508.00	659,459,844.56	6,942,656.00	676,939,944.15	1,336,399,789
2	Ард секьюритиз ХХК	743,486.00	385,512,053.13	412,089.00	123,728,527.92	509,240,581
3	Голомт Капитал ХХК	2,589,167.00	192,848,208.98	2,274,345.00	184,673,157.38	377,521,366
4	Алтан хоромсог ХХК	-	-	207,462.00	217,513,089.00	217,513,089
5	Бумбат-Алтай ХХК	389,441.00	105,085,416.87	2,079,679.00	99,737,093.01	204,822,510
6	Ти Ди Би Капитал ХХК	886,727.00	87,670,234.12	271,879.00	76,071,879.92	163,742,114
7	Стандарт инвестмент ХХК	605,206.00	81,261,063.13	243,490.00	55,592,439.88	136,853,503
8	Алекс Капитал ҮЦК	943,434.00	75,252,253.60	379,378.00	60,596,040.68	135,848,294
9	Гаули ХХК	14,467.00	4,383,608.71	195,836.00	126,128,618.95	130,512,228
10	Инвекор капитал ХХК	15,773.00	40,853,551.08	9,140.00	24,617,092.65	65,470,644
11	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	297,987.00	35,854,815.74	160,797.00	26,617,299.19	62,472,115
12	Ард капитал групп ХХК	157,670.00	22,190,450.81	321,894.00	38,769,763.20	60,960,214
13	Монсек ХХК	323,328.00	36,051,872.00	10,071.00	5,500,871.50	41,552,744
14	Новел инвестмент ХХК	29,269.00	22,600,730.20	288,476.00	11,989,596.32	34,590,327
15	Зэргэд ХХК	124,970.00	13,369,203.78	141,433.00	16,826,067.98	30,195,272
16	Нэйшнл сэкьюритис ХХК	59,101.00	8,948,891.32	7,831.00	16,224,048.29	25,172,940
17	Гүүдсек ХХК	213,563.00	18,841,121.03	11,644.00	5,653,670.60	24,494,792
18	Централ секьюритиз ҮЦК	139,333.00	4,740,153.30	161,339.00	18,326,086.09	23,066,239
19	Гранддевелопмент ХХК	160,765.00	8,495,506.90	77,561.00	12,520,903.50	21,016,410
20	Таван богд ХХК	39,263.00	14,699,432.06	12,682.00	224,056.63	16,923,489

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.09.30-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /% /
1	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	4,731,202	449,196,431	88	76	3.53
2	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	388,601	433,079,961	1,460	1,021	34.11
3	MFC	МОНОС ХҮНС	2,685,153	183,939,970	74	58	11.18
4	APU	АПУ	224,286	127,928,323	590	550	-2.49
5	LEND	ЛЭНДМН ББСБ	2,726,880	81,807,855	32	29	-7.69
6	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	91,460	79,493,548	900	849	-1.50
7	INV	ИНВЕКОР ББСБ	29,641	78,127,848	2,800	2,550	5.46
8	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	1,340,539	57,692,562	45	42	-2.89
9	BODI	БОДЬ ДААТГАЛ	477,577	54,570,148	121	108	-3.49
10	TTL	ТАВАН ТОЛГОЙ	7,294	42,433,550	6,020	5,500	-1.38
11	GOV	ГОВЬ	159,459	31,788,645	205	190	0.86
12	ADB	АРД КРЕДИТ ББСБ	433,002	28,123,649	68	62	0.74
13	TUM	ТҮМЭН ШУВУУТ	155,778	24,112,300	168	145	-3.81
14	MNP	МОНГОЛ ШУУДАН	37,273	21,662,555	620	555	-3.63
15	AIC	АРД ДААТГАЛ ХК	26,426	18,479,012	730	670	-5.78
16	SUU	СҮҮ	69,918	14,303,091	212	199	5.23
17	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	10,289	13,653,555	1,499	1,100	-5.31
18	NEH	ДАРХАН НЭХИЙ	481,616	7,024,443	15	14	2.95
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	36,815	6,976,309	195	181	0.60
20	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	44,374	6,288,286	143	135	-0.71



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.09.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %/
			2020-09-01	2020-09-30		
1	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	388,601	1,029.00	1,380.00	351.00	34.11
2	ЖУУЛЧИН ГОВЬ	5	7,900.00	10,400.00	2,500.00	31.65
3	ХЭРЛЭН ХИВС	581	37.00	48.00	11.00	29.73
4	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	15	62,150.00	75,000.00	12,850.00	20.68
5	ШАРЫН ГОЛ	547	840.00	1,000.00	160.00	19.05
6	БИ ДИ СЕК	415	716.00	850.00	134.00	18.72
7	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	201	68.00	80.00	12.00	17.65
8	ХАР ТАРВАГАТАЙ	20	4,300.00	4,945.00	645.00	15.00
9	МОН НАБ	1	4,500.00	5,175.00	675.00	15.00
10	СИЛК НЕТ	50	720.00	828.00	108.00	15.00
11	ТЕХНИК ИМПОРТ	1	7,005.00	8,055.00	1,050.00	14.99
12	ТЭЭВЭР ДАРХАН	1	7,475.00	8,595.00	1,120.00	14.98
13	АВТО ИМПЕКС	1	1,030.00	1,184.00	154.00	14.95
14	ДОРНОД ХУДАЛДАА	1	20,100.00	23,100.00	3,000.00	14.93
15	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	18,880	90.00	102.94	12.94	14.38
16	ШИВЭЭ ОВОО	1,633	1,750.00	2,000.00	250.00	14.29
17	ОРХОНДАЛАЙ	1	1,500.00	1,700.00	200.00	13.33
18	ГОНИР	231	800.00	900.00	100.00	12.50
19	МОНОС ХҮНС	2,685,153	62.96	70.00	7.04	11.18
20	БАГАНУУР	309	900.00	1,000.00	100.00	11.11

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.09.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2020-09-01	2020-09-30		
1	БЭРХ УУЛ	390	600.00	375.00	-225.00	-37.50
2	ХИШИГ УУЛ	93	682.00	500.00	-182.00	-26.69
3	ГАН ХИЙЦ	6	12,000.00	9,000.00	-3,000.00	-25.00
4	ОЛЛОО	4,496	62.90	52.00	-10.90	-17.33
5	СЭЛЭНГЭ СҮРЭГ	30	5,000.00	4,250.00	-750.00	-15.00
6	МОНИНЖБАР	30,830	115.00	99.00	-16.00	-13.91
7	АРИГ ГАЛ	794	3,000.00	2,600.00	-400.00	-13.33
8	МОНГОЛ САВХИ	618	550.00	480.00	-70.00	-12.73
9	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	74	2,600.00	2,300.00	-300.00	-11.54
10	ТӨМРИЙН ЗАВОД	20	7,640.00	6,800.00	-840.00	-10.99
11	СОР	162	645.22	575.00	-70.22	-10.88
12	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	1,769	143.00	130.00	-13.00	-9.09
13	ХӨХ ГАН	2,150	87.00	79.88	-7.12	-8.18
14	ЛЭНДМН ББСБ ХК	2,726,880	31.47	29.05	-2.42	-7.69
15	МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	5	4,000.00	3,750.00	-250.00	-6.25



"CFA RESEARCH CHALLENGE" ТЭМЦЭЭНИЙ НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО



Өнөөдөр буюу 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Монголын Итгэмжлэгдсэн Санхүүгийн Шинжээчдийн Нийгэмлэгээс уламжлал болгон зохион байгуулдаг олон улсын "CFA Research Challenge" тэмцээний нээлт болж, тус нийгэмлэгийн ерөнхийлөгч С.Дашдорж Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6315 дахь удаагийн арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

Энэ жилийн тэмцээнийг Монголд хөрөнгийн зах зээл үүсч хөгжсөний 30 жилийн ойг угтан Монголын Хөрөнгийн бирж хамтран зохион байгуулж байна. Тэмцээнд манай улсаас 7 их, дээд сургуулийн 9 баг бүхий 45 оюутан оролцож, "Мандал даатгал" ХК-ийн үйл ажиллагаанд судалгаа хийх бөгөөд тэмцээнд түрүүлсэн баг, оюутнууд Ази, Номхон далайн бүсийн тэмцээнд оролцон өрсөлдөх юм.

Өнгөрсөн 4 жилд нийтдээ 100 гаруй оюутан хамрагдсан бөгөөд Монголын баг Азийн шилдэг 5 багийн нэгээр шалгарч байсан байна.



ЗАРИМ КОМПАНИУДЫГ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.10 дахь заалтууд, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.11 дэх заалтууд болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 8/4031, 11/3130 дугаар албан тоотуудыг тус тус үндэслэн гаргасан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А/66 тоот тушаалаар Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны арилжааг нь зогсоосноос хойш дараалсан 5-аас дээш жил арилжааг сэргээгээгүй "Өргөн хэрэглээ" ХК, "Эсгий гутал" ХК болон Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй "Бороогийн үйлдвэр" ХК, "Дизель зуухны угсралт, засварын газар" ХК, "Ноёт хайрхан" ХК-ийг тус тус Монголын хөрөнгийн биржийн бүртгэлтэй хувьцаат компанийн бүртгэлээс хаслаа.

ХУУЛЬ ЖУРМААР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА КОМПАНИУДАД АНХААРУУЛГА ӨГЛӨӨ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг хангуулах замаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа билээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд, МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлага хангахгүй байгаа хувьцаат компаниудад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх талаар үүгээр мэдэгдэж байна. Заасан хугацаанд холбогдох зөрчлийг арилгаагүй компаниудыг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авахыг анхааруулж байна. Үүнд:

№	Симбол	Компанийн нэр
1	ARH	"Сэлэнгэ Ар хөвч" ХК
2	ATI	"Агротехимпекс" ХК
3	ALA	"Алтай нэгдэл" ХК
4	CND	"АСБИ" ХК
5	MDZ	"Монгол дизель" ХК
6	NUR	"Нийслэл өргөө" ХК
7	SES	"Сэлэнгэ-сүрэг" ХК
8	IND	"Эрдэнэт-Зандан" ХК
9	ORD	"Орхондалай" ХК
10	TSA	"Цагаантолгой" ХК
11	SIL	"Силикат" ХК
12	BHR	"Бинсэ" ХК
13	SSG	"Сонсголон бармат" ХК
14	AAR	"Автозам" ХК
15	HMK	"Ханын материал" ХК



16	BBD	"Стандарт проперти групп" ХК /Баянбогд/
17	BOR	"Борнуур" ХК
18	ALD	"Азык" ХК
19	JGL	"Говийн өндөр" ХК
20	DMA	"Дэвшил мандал" ХК
21	INT	"Ингэттолгой" ХК
22	KEK	"Монгол керамик" ХК
23	MBG	"Мон Ит Булигаар" ХК
24	ACL	"Тээвэр-Ачлал" ХК
25	TVT	"Хар тарвагатай" ХК
26	HVL	"Хөвсгөл" ХК
27	HTS	"Хөтөлийн цемент шохой" ХК
28	TAS	"Эрдэнэт хүнс" ХК
29	ECV	"Эрэнцав" ХК
30	EAZ	"Эрдэнэт авто зам" ХК
31	SVR	"Эрдэнэт Суврага" ХК
32	BAJ	"Глобал лайф технологи" ХК
33	BAZ	"Люкс занаду групп" ХК
34	ANO	"Анод банк" ХК
35	DRN	"Дорнод" ХК
36	ZSB	"Зоос банк" ХК
37	ULZ	"Өлзий-Дундговь" ХК
38	HUT	"Хөдөөгийн тээвэр" ХК
39	HAH	"Хүнс-Архангай" ХК
40	SIM	"Шим" ХК
41	BTL	"Баянталбай" ХК
42	HML	"Глобал монголиа холдингс" ХК
43	GNR	"Гонир" ХК
44	DAO	"Хуртай" ХК
45	TVL	"Тавилга" ХК
46	HRL	"Хэрлэн хивс" ХК

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН ХУВЬЦААТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖ МЭДЭЭЛЭЛ

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрээр компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах болсонтой холбогдуулан Монголын хөрөнгийн биржид хандаж, ногдол ашиг авах, үнэт цаасны данс нээлгэх, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн

1072 ширхэг хувьцааг арилжаалах боломжтой эсэх асуудлаар тайлбар, мэдээлэл хүсч байгаа иргэдийн тоо ихээхэн нэмэгдэж байгаатай холбогдуулан дараах мэдээллийг хүргэж байна. Үүнд:

Ногдол ашгаа хэрхэн авах вэ?

Та үнэт цаасны компанидаа хандан дансаа баталгаажуулснаар ногдол ашгаа хүлээн авах бөгөөд "ҮЦГХТ" ХХК-иас ногдол ашгийн гүйлгээг долоо хоногт багцлан нэг удаа гүйцэтгэж байна. Ковид-19 цар тахлын эрсдлийг бууруулах зорилгоор үнэт цаасны дансгүй эсвэл дансаа баталгаажуулаагүй иргэд ebarimt-ийн аппликэйшн ашиглан ажлын 3 хоногт ногдол ашгаа хүлээн авах боломжийг олгоод байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ebarimt.mn хуудсаар авна уу.

Үнэт цаасны данс хэрхэн нээлгэх вэ?

Хэрэв иргэн үнэт цаасны данс нээлгэхийг хүсвэл юуны түрүүнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн цахим хуудас, "1072 хувьцааны мэдээллийн төв"-ийн цахим хуудас эсвэл 158989 дугаарт регистрийн дугаараа латин үсгээр бичиж илгээснээр өмнө нь үнэт цаасны данс нээлгэж байсан эсэхээ шалгаж болно. Үнэт цаасны данстай бол дахин нээлгэх шаардлагагүй.

Үнэт цаасны дансыг 2018 оноос эхлэн цахимаар нээх боломжтой болсон тул иргэд заавал үнэт цаасны компани дээр биеэр очихгүйгээр дансаа нээлгэж болно. Уг дансыг хөрөнгийн биржид бүртгэлтэй аливаа компанийн хувьцааны арилжаанд оролцох, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг хөрөнгийн биржид бүртгэгдсэний дараа арилжаалах үед ашиглана. Үнэт цаасны данс нээлгэх компанийг сонгохдоо тус компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх, үйлчилгээний чанар, хүртээмж, үнэ өртөг зэргийг харгалзан үзэж шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Өнөөдрийн байдлаар дараах үнэт цаасны компаниуд цахимаар данс нээх үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

"Апекс Капитал ҮЦК" ХХК - <https://dbx.apex.mn/>
 "Ард Капитал ҮЦК" ХХК - <http://dbx.ardcapital.mn>
 "Ард Секюритиз ҮЦК" ХХК - <http://ardsecurities.com/>
 "БиДиСЕК ҮЦК" ХК - <https://reg.bdsec.mn/>

"Бумбат Алтай ҮЦК" ХХК - <http://dbx.bumbat.mn/>

"Гаули ҮЦК" ХХК - <http://www.gauli.mn/>

"Голомт Капитал ҮЦК" – SocialPay
 "Гүүдсек ҮЦК" ХХК - <https://goodsec.mn/online>

"Масдак ҮЦК" ХХК - <http://masdaq.msem.mn/login>

"Өндөрхаан ҮЦК" ХХК - <https://undurkhaan.msem.mn/>

"ТиДиБи Капитал ҮЦК" ХХК - <https://www.tdbcapital.mn/page/open-brokerage-account>

"Стандарт Инвесмент ҮЦК" ХХК - <https://>



“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖ МЭДЭЭЛЭЛ

dbx.standardinvestment.mn/

"Тэнгэр Капитал ҮЦК" ХХК - <https://xacex.tengercapital.mn/>

Мөн "Эрдэнэс таван толгой" ХК-ийн ЕТТ гар утасны апплейкшнээр дамжуулан 20 гаруй үнэт цаасны компаниудад данс нээлгэх боломжтой юм.

Монголын хөрөнгийн биржийн нийт гишүүн брокерийн компаниудын хаяг байршлын мэдээллийг Энд дарж үзнэ үү.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаагаа худалдах, өв залгамжлал хийлгэх боломжтой юу?
Одоогоор боломжгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 350 дугаар тогтоолын дагуу, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг түүний хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдэх хүртэл бусдад худалдах, шилжүүлэхгүй байхаар заасан байдаг. Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржид арилжаалагдаж эхлэх хүртэл бусдад шилжүүлэх, худалдах боломжгүй бөгөөд хөрөнгийн биржээр хувьцаа нь арилжаалж эхлэхийн тулд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нээлттэй хувьцаат компани хэлбэрээр Монголын хөрөнгийн биржид бүртгүүлсэн байх, Санхүүгийн зохицуулах хорооноос хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг өгсөн байх шаардлагатай юм.

Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь хаалттай хувьцаат компани буюу Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, хувьцааны арилжаа эхлээгүй байгаа тул иргэд өөрийн эзэмшлийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэх боломжгүй байна.

Үйл явдал

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" нь Баян Х өндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-г National Instrument 43-101 тайлагналын стандартын дагуу боловруулж, Канад улсын цахим тайлангийн SEDAR системд бүртгүүлсэн байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2019 оны ногдол ашиг тараагдаж эхэлсэнтэй холбоотойгоор олон нийтийн сүлжээгээр /facebook, twitter, зарын сайт гэх мэт/ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг худалдан авах, барьцаалж зээл олгох, ногдол ашгийн мөнгийг шуурхай олгоход туслана гэх зэрэг худал мэдээ, мэдээлэл гарч байна.

Иймд иргэн Та цахим орчинд тавигдаж буй мэдээ, мэдээллийг сайтар нягталж, эрх бүхий байгууллагаас гаргасан зөвлөмж, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн олон нийттэй харилцах алба, өөрийн хувьцааны данс нээлгэсэн үнэт цаасны компаниас 1072 ширхэг хувьцааны ногдол ашгийн талаарх мэдээллийг тодруулж өөрийгөө эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг хүсье.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN